



SUSTAINABLE
PLASTIC
RECYCLING
IN MONGOLIA

ХУВАНЦАР ХОГ ХАЯГДЛЫН ДАХИН БОЛОВСРУУЛАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ
ЯВУУЛАХ ЭРХЗҮЙН ТААТАЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ
БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН
ТАЙЛАН

(SC_MN20F23011701 / BE_AG23_01)



Bayalageco

2023

Энэхүү тайланг Европын Холбооны Switch-Asia хөтөлбөрийн санхүүжилттэй хэрэгжиж буй “Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах төсөл”-ийн хүрээнд Монголын байгаль орчин, аюулгүй байдлын төв ТББ-ын захиалгаар Баялаг Эко ХХК боловсруулав. Тус тайлангийн агуулга нь Европын Холбооны байр суурийг илэрхийлээгүй болно.

Судалгаа хийсэн зөвлөхүүд

Но	Нэр	Албан тушаал	Байгууллага
1	Н. Энхбаясгалан	Зөвлөх, Гүйцэтгэх захирал	Баялаг Эко ХХК
2	Б. Дэлгэрбаяр	Зөвлөх	
3	С. Аригуун	Зөвлөх	
4	Н. Ариунаа	Зөвлөх	

Судалгааны ажлын хэсгийн гишүүд

Но	Нэр	Албан тушаал	Байгууллага
1	Д. Батжаргал	Тэргүүн	Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо
2	С. Баярцэцэг	Мэргэжилтэн	БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар
3	Н. Гэрэлцэцэг	Мэргэжилтэн	БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэс
4	Ц. Мандхайхатан	Гүйцэтгэх захирал	Бодлогод залуусын хяналт ТББ
5	Д. Мөнхбаатар	Цуглуулах албаны ахлах менежер	Ти Эм Эл ХХК
6	Н. Уянга	Төсөл, гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга	Баянзүрх дүүргийн ЗДТГ
7	М. Байгаль	Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн	Налайх дүүргийн ЗДТГ
8	С. Оюунгэрэл	Орлого, олон нийтийн байцаагч	Налайх Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ
9	Д. Гантуул	Орчны бохирдол, хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтэн	Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ
10	О. Лхагвасүрэн	Гүйцэтгэх захирал	Түвшин Сайхан Мөнх НҮТББ
11	Ц. Булганмөрөн	Удирдах зөвлөлийн гишүүн	Хоггүй Монгол ТББ
12	Б. Отгонбат	Менежер	Сонгинохайрхан дүүргийн "Тохижилт Цэвэрлэгээ Үйлчилгээ" ОНӨААТҮГ-ын менежер
13	З. Индаръяа	Мэргэжилтэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдлын удирдлагын хэлтэс
14	Н. Эрдэнэсайхан	Тэргүүн	Монголын байгаль орчин аюулгүй байдлын төв ТББ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуй нэгж, байгууллагууд
БЖДҮ	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэл
БЖДҮ	Бичил, жижиг, дунд үйлдвэр
БОАЖ-ын сайд	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол улс
МХХДБҮХ	Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбоо
НИТХ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮТББ	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СХЗГ	Стандартчилал хэмжилзүйн газар
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын их хурал
ҮИХ	Үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлага
ХАА	Хөдөө аж ахуй

1 ОРШИЛ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол улсад хэрэгжиж буй хууль тогтоомжийн хуванцар хаягдлын менежментийн зохицуулалтын уялдаа холбоо, хэрэгжилтийн дүн шинжилгээг бодлогын судалгааны арга зүйд тулгуурлан хийнэ. Үүний тулд хууль эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл, тулгамдаж буй асуудал, учир шалтгааныг судлан, шийдвэрлэх арга замыг тэргүүлэх ач холбогдлоор нь бусад улс орны эрх зүйн зохицуулалт, практиктай харьцуулан судалсны үндсэн дээр бодлогын баримт бичигт тусгахад шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг санал болгох юм.

Хуванцар дахин боловсруулах БЖДҮ-үүд, хуванцар бүтээгдэхүүн, хуванцар хог хаягдал үүсгэгчид (үйлдвэрлэгч, импортлогч, өрх, ААН-ийг оруулаад), холбогдох төрийн байгууллагууд, хуванцар хог хаягдлыг ангилах, цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхэлж буй албан болон албан бус хувь хүн/хуулийн этгээдүүд нь энэхүү судалгааны ажлын зорилтот бүлэг юм.

2 ХУВАНЦАР ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТТЭЙ ХОЛБОГДОХ ЭРХЗҮЙН ОРЧНЫ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1 Хог хаягдлын хууль эрхзүй, бодлого, хөтөлбөрүүдийн тойм

Манай улс Хог хаягдлын тухай хуулийг 2017 онд УИХ-аар шинэчлэн батлуулсан бөгөөд тус хуулиар энгийн болон аюултай хог хаягдалтай холбоотой буюу хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

Тус хууль нь хог хаягдлын цогц менежментийн талаар анх удаа тусгасан төдийгүй төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрх үүрэг, хог хаягдал цуглуулж, тээвэрлэх, сэргээн ашиглах, дахин боловсруулах, урьдчилан боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх болон зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагыг нарийвчлан тусгасан, аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулсан зохицуулалт бий болсон, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагааг эрхэлсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, үйлдвэрлэсэн болон импортолсон зарим бараа бүтээгдэхүүний хэрэглээнээс үүсэх хаягдал, сав баглаа боодлыг эргүүлэн татаж цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах асуудлыг үйлдвэрлэгч болон импортлогч нь хариуцах, хог хаягдлын боловсрол олгох асуудлуудыг тусгасан зэрэг олон давуу талтай.

Хог хаягдлын тухай хуульд нийцүүлэн энгийн хог хаягдлын дараах журам, аргачлал, жагсаалтуудыг боловсруулан баталж, дагаж мөрдөж байна. Үүнд:

- Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага, БОАЖ-ын сайдын 2018.11.17 ны өдрийн А/443 тоот тушаал
- Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх маягт, Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагааны тайлангийн маягт, БОАЖ-ын сайдын 2018 оны 11 сарын 19 -ны өдрийн А/444 тушаал
- Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт, БОАЖ-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 11-р сарын 13-ны өдрийн А-429/257 тушаал

- Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл, БОАЖ-ын сайдын 2017 оны 12-р сарын 12-ны өдрийн А/349 тушаал
- Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам, БОАЖ-ын сайдын 2018 оны 11 сарын 12-ны өдрийн А/428 тушаал
- Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай, Монгол улсын засгийн газрын 2018 оны 6 сарын 20-ны өдрийн 189 тоот тогтоол
- Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодолсон жагсаалтад нэмэлт оруулах тухай, Монгол улсын засгийн газрын тогтоол, 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн No199 тогтоол
- Байгаль орчинд ээлтэй арга, технологи нэвтрүүлсэн хувь хүн, аж ахуйн нэгжийг урамшуулах журам, Засгийн газрын 2017 оны 290-р тогтоол
- Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоол
- Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/492 захирамж
- Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулах гэрээ. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн А/492 захирамж

Мөн түүнчлэн хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлын үүсэх хэмжээг бууруулах, дахин боловсруулах, дахин ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр дараах бодлогын баримт бичгүүдэд тусгасан байдаг. Үүнд:

- Алсын хараа-2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалд тусгасан үйл ажиллагаа
- Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр, 2014
- Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Нийслэл Улаанбаатар хотыг 2021-2025 онуудад хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл
- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020 -2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааны төлөвлөгөө

Хог хаягдлын талаар зохицуулалтуудыг байгаль хамгаалах болон бусад холбогдох хуулиудад дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- **Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь** хүрээлэн буй орчны удирдлагын тогтвортой хөгжлийн зарчмуудыг хуульчилсан, холбогдох бусад хуулиудад тусгагдсан зарчмууд, тавигдах шаардлагуудыг өргөн хүрээнд тодорхойлсон цогц хууль юм. Тус хуулийн 21-р зүйлд иргэн, аж ахуй нэгж байгууллагын үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулахгүй байх үүргийг зааж өгсөн ба мөн байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн бүртгэлийг төрийн захиргааны төв байгууллага хөтлөх, цацраг идэвхт болон химийн хортой, аюултай бодис, тэдгээрийг агуулсан нэгдлийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмыг хуулиар, үйлдвэрлэл, ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, боловсруулах, булах, устгах журмыг Засгийн газар тус тус тогтооно гэж тус тус заасан байдаг.
- **Химийн хорт болон аюултай бодисын тухай** хуулиар химийн хорт бодисуудын импорт, экспорт, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт болон хяналтын үйл ажиллагааг зохицуулдаг ба химийн хорт болон аюултай бодисын хаягдал болон химийн хорт болон аюултай бодисыг устгахыг тодорхойлсон байдаг.

- **Газрын тухай хууль** -ийн 16-р зүйлд аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж барих газар нь Улсын тусгай хэрэгцээний газарт дараах газарт хамаарна гэж заасан байдаг.
- **Усны тухай** хуулийн хог хаягдалтай холбоотой заалт нь усны сан бүхий газарт цацраг идэвхт болон химийн хорт бодис, халдвар үүсгэгч, хог хаягдал, бохир ус хаях, хадгалах, машин техник, бохир зүйлс угаахыг хориглоно гэсэн байна.
- **Агаарын тухай** хуулийн 16-р зүйлд зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаахыг хориглоно, 17-р зүйлд хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатаах, устгах үйл ажиллагааны улмаас агаарт ялгарах хаягдлын стандартыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулна. 20-р зүйлд зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах стандартын шаардлага хангаагүй аливаа үйл ажиллагааг хориглоно хэмээн тус тус заажээ.
- **Зөвшөөрлийн тухай хууль** нь 2022 онд шинэчлэн батлагдсан бөгөөд энэ хуулийн 8.1-р зүйлд аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх болон энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн, хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэхэд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахаар заасан байна.
- **Хот байгуулалтын тухай** хууль нь 2008 онд шинэчлэн найруулагдсан ба Монгол улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг хот төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэлийг хот байгуулалтын норм ба дүрэм, журмын дагуу төлөвлөж тогтоох ба хатуу хог хаягдлын цэг нь тусгай зориулалтын бүсд хамрагдана.
- **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай** хуулийн 10-р зүйлд Монгол Улсын гарал үүсэлтэй болон хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээдэд Захиалагч тендерийн үнэлгээ хийхдээ давуу эрх олгоно гэж заасан байгаа бол 3-р зүйлд нийслэлийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх нийслэл хотын хот тохижилт, авто замын засвар, арчилгаа, хог хаягдалтай холбоотой ажил, үйлчилгээг худалдан авах харилцааг энэ хуулиар зохицуулахгүй гэж тус тус заажээ.
- **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай** хууль нь 2019 онд шинэчлэгдэн найруулагдсан ба тус хуулийн 22-р зүйлд байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварын хөнгөлөлт үзүүлэх тухай заасан.
- **Зар сурталчилгааны тухай хуулийн** 15-р зүйлд иргэн, хуулийн этгээдээс нийтийн болон улсын эрх ашигт нийцсэн ашиг тустай үйлс, иргэдэд хог хаягдлын талаар боловсрол олгохыг дэмжин тэтгэх зорилгоор зар сурталчилгааг бүтээх, түгээх, эсхүл өөрийн хөрөнгийг энэхүү зар сурталчилгааг бүтээх, түгээхэд зориулан бүсдэд хариу төлбөргүйгээр шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг нийгмийн зар сурталчилгаанд хамааруулж, хууль тогтоомжид заасны дагуу хөнгөлөлт үзүүлж болно.
- **Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай** хуулийн 5-р зүйлд хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор үйлдвэрлэл, технологийн парк байгуулна гэж заажээ.

Эдгээрээс гадна Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал хэмжилзүйн газар (СХЗГ) болон Хотын стандарт, хяналтын газраас хог хаягдал болон хуванцар бүтээгдэхүүнтэй холбоотой дараах стандартуудыг боловсруулж баталсан байна. Үүнд:

- MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
- MNS 0017-2-0-07:1979. Агаарыг бохирдуулах хаягдал. Ангилал

- MNS 3221:1982. Хуванцар материал ба түүгээр хийсэн бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх журам. Аюулгүйн техникийн шаардлага
- MNS 6008:2009. Хуванцрын галд тэсвэршилтийг тодорхойлох
- MNS 6667:2017. Хуванцар савны найрлагыг тодорхойлох нил улаан туяаны спектрофотометрийн арга
- MNS 1010:1986. Хүнсний бүтээгдэхүүнд зориулсан хуванцар сав. Ерөнхий техникийн нөхцөл
- MNS 5580:2005. Хуванцар лонхны бэлдэц. Техникийн ерөнхий шаардлага
- MNS ISO 17422: 2011. Хуванцар- Байгаль орчны аспект –Стандартад байгаль орчны асуудлыг тусгах ерөнхий арга зүйн заавар
- UCS 1701A Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент
- UCS 1703A Аюултай хог хаягдлын менежмент
- UCS 1705A Хог хаягдлын устгалын стандарт, устгалын удирдамж
- UCS 1706A Барилгын хог хаягдлын менежмент
- UCS 1406B Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байршуулах хогийн саванд тавих шаардлага

2.2 Хуванцар хог хаягдлын дахин боловсруулах үйл ажиллагаанд тулгарч буй асуудлын дүн шинжилгээ

Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаатай холбогдох хууль эрхзүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийхийн тулд судалгааны багийн зөвлөхүүд 2023 оны 1-р сарын 20-ны өдрөөс 2023 оны 3-р сарын 3 хүртэлх хугацаанд холбогдох талуудтай уулзалт, хэлэлцүүлэг хийж, хуванцар хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаанд оролцогч талууд болон тэдгээрт тулгарч буй асуудлуудыг тодорхойлсон.

Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаанд дараах оролцогч талууд байна. Үүнд:



Зураг 1. Хуванцрын хог хаягдлын оролцогч талууд

Улмаар тэдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээ, зохицуулалтуудыг хууль эрх зүйн баримт бичгүүдэд хэрхэн тусгасан талаар дүн шинжилгээг хийлээ.

Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаанд дараах гол асуудлууд тулгарч байна гэж оролцогч талууд тодорхойлов. Үүнд:

- **Хуванцар хог хаягдлын нэр томьёо, тодорхойлолт, ангиллын стандарт байхгүй.** Хог хаягдлын тухай хуулийн нэр томьёоны хэсэгт хуванцар хог хаягдлын тусгайлсан тодорхойлолт, ангилал байхгүй байна. Химийн бодисын сав баглаа, боодлын хуванцар хаягдал нь аюултай хог хаягдалд хамрагдаж байгаа бол бусад хуванцар энгийн хог хаягдал хамрагдаж байна. Мөн түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээ, ХАА, эмнэлгийн, уул уурхайн үйл ажиллагаанаас гарч буй хуванцар хаягдлын судалгаа дутмаг, нарийвчилсан зохицуулалт, ангилал, нэршил, стандарт манай улсад одоогоор байхгүй байна.
- **Хуванцар дахин боловсруулсан бараа бүтээгдэхүүн нийлүүлэхээр тендерт давуу эрх эдэлж чаддаггүй.** Хог хаягдлын тухай хууль 2017 онд шинэчлэн батлагдсантайгаар холбоотой Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10-р зүйлд *“Монгол Улсын гарал үүсэлтэй болон хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээдэд захиалагч тендерийн үнэлгээ хийхдээ давуу эрх олгоно”* гэж өөрчлөлт оруулсан. Гэсэн хэдий ч *“Тендерт оролцогчид давуу эрх олгох аргачлал”*-ын 2.1.1. -д тус хуулийн 10.1.1-д заасан *“Хог хаягдал дахин боловсруулсан бараа нийлүүлэх тендер ирүүлсэн этгээд”* гэсэн хэсэг нь орхигдсоны улмаас хуванцар дахин боловсруулж бараа, бүтээгдэхүүнд давуу эрх олгогдож чаддаггүй байна.
- **НӨАТ болон ААН-ийн орлогын албан татварын хөнгөлөлт байдаггүй.** Хуванцар хог хаягдал дахин боловсруулдаг, дахин ашигладаг аж ахуйн нэгж, байгууллага нь дахивар цуглуулагч болон иргэдээс хаягдал худалдан авдаг бөгөөд тэдгээр иргэд НӨАТ-ын баримт өгөх боломжгүйн улмаас хуванцар хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь хаягдал түүхий эд худалдан авсан зардлаа татварын системд баримтжуулах боломжгүй болдог. Нөгөөтээгүүр хаягдал дахин ашиглан, дахин боловсруулж хийсэн бүтээгдэхүүний орлогоос НӨАТ болон аж ахуйн нэгжийн орлогын албан татвар зэрэг татваруудыг төлдөг нь санхүүгийн болон татварын дарамтыг бий болгодог. Улмаар хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах замаар бий болгосон бараа, бүтээгдэхүүний зардал өндөр болж, үнэ өртгийн хувьд ижил төстэй импортын бүтээгдэхүүнтэй өрсөлдөх боломжгүй байдаг.
- **Хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлдөггүй.** Ийм учраас тоног төхөөрөмжүүдийн импортлох зардал өндөр болж, хуванцар дахин боловсруулах үйлдвэрлэл хөгжих боломж мүү.
- **Үүсгэгч нь хариуцах, бохирдуулагч нь төлөх зарчим хэрэгждэггүй.** Хог хаягдлын тухай хуулийн 8.1.14. *“Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах”,* 40.5. *“Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй”* хэмээн тус тус заасан хэдийн ч үйлдвэрлэгчид болон импортлогчид бараа, бүтээгдэхүүн, тэдгээрийн сав, баглаа, боодлоос гарч байгаа хог хаягдалд ямар ч анхаарал тавьдаггүй, үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлага сул байгаатай холбоотойгоор хаягдлаа зөвхөн хэрэглэгчид болон дахин боловсруулагчдад даатгаад орхидог бөгөөд эдгээр хог хаягдлыг цуглуулах, устгахад төсвөөс болон хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогоос ихээхэн хөрөнгө зарцуулж байна.
- **Хуванцар хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх нэгдсэн систем байхгүй тул хэд хэдэн нийлүүлэгчээр дамждаг нь түүхий эдийн үнийг өсгөдөг.** Хог хаягдлын тухай хуулийн 9.4.2-т заасан *“Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж,*

байгууллагыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах” 14.2-р зүйлд “Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ”, 14.3-р зүйлд “Энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно” гэж тус тус заасан нь хуванцрын хог хаягдлыг үүсгэгчээс цуглуулах, тээвэрлэхэд хүндрэл учруулж улмаар хуванцрын хаягдлыг олон шат дамжлага гарган цуглуулах, тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, хуванцар хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдийн түүхий эдийн үнийг өсгөх, түүхий эдийн хомсдолд орох гол нөлөөлөл болдог байна.

- **Дахивар хаягдлыг эх үүсвэр дээр ангилсан, цуглуулж тээвэрлэсэн, дахин ашигласан, дахин боловсруулсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох механизм, эдийн засгийн хөшүүрэг дутагдалтай.** Хог хаягдлын тухай хуулийн 40.4-р зүйлд *“Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно”, хуулийн 9.1.5 “Энэ хуулийн 40.4 заасан урамшуулал олгох журмыг батлах”* гэж тус тус заасан боловч хуулийн хэрэгжилт нийслэлийн хэмжээнд хэрэгжээгүй, одоог хүртэл журмыг батлаагүй байна.
- **Шинжлэх ухаан, инновацын асуудал дутмаг.** Хог хаягдлын менежментэд эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагатай хамтрах, судалгаа, шинжилгээний үр дүнг нэвтрүүлэх асуудал дутмаг. Хэдийгээр Хог хаягдлын тухай хуулийн 8.4.4-р зүйлд Хог хаягдлын талаар боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд *“Хог хаягдалтай холбоотой үүссэн бохирдлыг тогтоох, цэвэрлэх, бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах арга, технологийн талаар судалгаа хийх, дэвшилтэт технологи, арга зүйн талаар зөвлөмж боловсруулах”* гэж заасан боловч энэхүү заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Хуванцар хог хаягдлын менежменттэй холбоотой бусад асуудлууд болон тэдгээрийн зохицуулалтуудын дараах хүснэгтэд тусгав.

Хүснэгт 1. Хуванцар хог хаягдлын менежменттэй холбоотой бусад асуудлууд болон тэдгээрийн зохицуулалтууд

Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
АНГИЛАН ЯЛГАХ, ХАДГАЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД		
Захиргаа, менежментийн асуудлууд	Эх үүсвэр дээр ангилан ялгалт хийх талаар иргэд, ААНБ-уудтай тогтвортой хамтран ажиллахад хүндрэлтэй.	Хог хаягдлын тухай хуулийн 10.2-р зүйлд хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүлээх үүргүүдэд хог хаягдлаа ангилан ялгах тухай заасан байдаг.
	Иргэд, ААНБ-ууд хог хаягдлаа ангилан ялгасан ч тээвэрлэх явцад холилддог.	Хог хаягдлын тухай хуульд ангилан ялгасан хогийг тус тусад нь тээвэрлэх талаар заалт байхгүй байна. НИТХ-ын 2020.02.20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор батлагдсан Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын 7.7.1. Орон сууц, аж ахуйн нэгжээс дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг долоо хоногт нэгээс доошгүй, дахин боловсруулах боломжгүй болон хүнсний органик хаягдлыг 7 хоногт 3-аас доошгүй удаа, гэр хорооны хог хаягдлыг ангиллын төрөл харгалзахгүйгээр сард 2-оос доошгүй удаа цуглуулж, ачиж тээвэрлэх; 7.7.5. Энгийн хог хаягдлыг холихгүйгээр ангиллын төрлийн дагуу ачиж, тээвэрлэх гэж тус тус заасан байна. UCS 1701A Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент гэсэн хотын стандартын 10. Ангилсан хогийг тээвэрлэх заавар хэсэгт Техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр ангилсан хаягдлыг тээвэрлэх гэж тусгасан байдаг.
Нийгмийн асуудлууд	Иргэд, ААНБ-ууд ангилан ялгах дадалд бүрэн суралцаагүй, сургалт, сурталчилгаа дутмаг. Телевиз, радио болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаар боловсрол олгох, хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөллийг сурталчлахад төлбөр өндөр, санхүүжүүлэхэд хүндрэлтэй.	Зар сурталчилгааны тухай хуулийн 15.1. Иргэн, хуулийн этгээдээс нийтийн болон улсын эрх ашигт нийцсэн ашиг тустай үйлс, иргэдэд хог хаягдлын талаар боловсрол олгохыг дэмжин тэтгэх зорилгоор зар сурталчилгааг бүтээх, түгээх, эсхүл өөрийн хөрөнгийг энэхүү зар сурталчилгааг бүтээх, түгээхэд зориулан бүсдад хариу төлбөргүйгээр шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг нийгмийн зар сурталчилгаанд хамааруулж, хууль тогтоомжид заасны дагуу хөнгөлөлт үзүүлж болно гэж заасан байдаг.
Технологи, дэд бүтцийн асуудлууд	Ангилан ялгах, хадгалах төрөлжсөн хогийн сав хот, хөдөө орон нутагт аль алинд нь хүрэлцээгүй.	НИТХ-ын 2020.02.20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор батлагдсан Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмын



Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
		<p>3.1.8. Барилга, байгууламжийг өргөтгөх, шинээр барихдаа түүний зориулалт, хүн амын нягтрал, хог хаягдлын үүсэх хэмжээ, ангиллын төрлөөс хамаарч хог хаягдал хадгалах байр, талбайн байршлыг барилга, байгууламжийн зураг, төсөлд тусгасан байх гэж заасан байдаг.</p> <p>UCS 1701A Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент гэсэн хотын стандартын</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдлын ангилан ялгах тэмдэглэгээ • Хог хаягдал цуглуулах саванд тавигдах ерөнхий шаардлага • Хогны савны загвар, төрөл • Хог хаягдал цуглуулах, хадгалах талбайн сонголт • Хог хаягдал ангилах зай талбайн шаардлага зэргийн тусгаж өгсөн байна.
	Нийтийн эзэмшлийн талбайд байрших савнаас бусад газарт тухайлбал, орон сууцны хороолол доторх болон гэр хорооллын гудамжинд байрлуулсан ангилан ялгах савуудыг ямар байгууллага хариуцан хогийн савыг суллах, тээвэрлэх, цэвэрлэгээ, үйлчилгээ хийх талаар журамд нарийвчлан тусгаагүй байна.	Орон сууцны хороолол болон гэр хорооллын гудамж талбайд тавьсан хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий хогийн савыг ямар байгууллага хариуцан суллах, тээвэрлэх, цэвэрлэгээ үйлчилгээ хийх талаар UCS 1701A стандартад тодорхой тусгах шаардлагатай.
ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА		
Захиргаа, менежментийн асуудлууд	Тээвэрлэлтийн хуваарь орон нутагт бараг байхгүй; Тээвэрлэлтийн хуваарь хотод үр дүнтэй мөрдөгдөх боломжгүй	Хог хаягдлын тухай хуулийн 14.4. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.
	Хог тээвэрлэлтийн шаардлага, стандарт мөрдөхөд хүндрэлтэй.	MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага болон заасан зүйл
	Зарим айл өрхөд хүрч үйлчлэхэд хүндрэлтэй	Нийслэлийн газар зохион байгуулалт, төлөвлөлттэй холбоотойгоор шийдвэрлэх асуудал.
	Төр, хувийн хэвшлийн түншлэл сул, хог хаягдлын талаар төрөөс гүйцэтгэж байгаа зарим ажлыг хувийн хэвшил болон ТББ гүйцэтгүүлэх санаачилга дутагдалтай	Хог хаягдлын тухай хуульд 14.2. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ. 41.1. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, төрөлжүүлэн ангилах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд төр,



Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
		хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлж болно гэж тусгасан байдаг.
	Хог хаягдлын менежментэд оролцдог төрийн захиргааны байгууллагуудын уялдаа, холбоо сул тул хамтран ажиллахад хүндрэлтэй;	<p>Хог хаягдлын тухай хуулийн 6-10-д зүйлд Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тус бүрд тусгаж өгсөн байдаг.</p> <p>41¹.1. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, төрөлжүүлэн ангилах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлж болно.</p>
Санхүү, эдийн засгийн асуудлууд	Хог хаягдлын хураамж, төлбөрийн хэмжээ бага, хураамж, төлбөр цуглуулалт хангалтгүйгээс хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаа хангалтгүй. Хог хаягдлын менежментэд зарцуулж байгаа зардал, алдагдлыг төсвөөс татаас өгч санхүүжүүлдэг боловч аймаг, сумын түвшинд хангалтгүй.	<p>Хог хаягдлын тухай хуулийн 41.1. Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө. 41.5. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааруулан тооцно. 41.6. Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно. 41.7. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно. 41.8. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ. 41.9. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна: 41.9.1. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх; 41.9.2. Хог хаягдлыг булшлах; 41.9.3. Энэ хуулийн 41.7-д заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөх. 41.10. Хог хаягдал цуглуулж тээвэрлэх үйл ажиллагааг энэ хуулийн 9.2.1-д заасан тарифыг үндэслэн цуглуулж, тээвэрлэсэн хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ. 41.11. Хог хаягдлыг булшлах үйл ажиллагааг энэ хуулийн 9.1.4-д заасан тарифыг үндэслэн булшилсан хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.</p>



Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
	Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах тариф, ажлын норм, стандарт, ажлын төсөв боловсруулах арга зүй, зөвлөмж, аргачлал байхгүйн улмаас хот, хөдөө ялгаатай тогтоодог.	Хог хаягдлын тухай хуулийн 8.1.10-д заасны дагуу энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах бөгөөд энэхүү аргачлалын дагуу 8.2.2. Барилгын хог хаягдлын норматив хэмжээг зам тээвэр, барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 8.3.4. Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын норматив хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 8.4.3. Боловсролын байгууллагын энгийн хог хаягдлын норматив хэмжээг боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүр тогтоох талаар заасан.
	ААНБ-ын хог хаягдлын хураамж, төлбөрийг тогтоох аргачлал, заавар хангалтгүй улмаас сум, дүүрэг харилцан адилгүй хураамж, төлбөрийн хэмжээг тогтоодог	Хог хаягдлын тухай хуулийн 8.7.1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлалыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулах; Тус аргачлалын дагуу 9.2.2. Тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг сум, дүүргийн ИТХ тогтоох тухай заасан байдаг.
	Хог хаягдлын хураамж, төлбөрийг нийслэлийн хувьд дэд бүтцийн байгууллагуудын төлбөртэй хамтатган цуглуулдаг боловч үйлчилгээ үзүүлсний хувь, хэмжээ өндөр (23 хувь) байдаг нь хог хаягдлын санхүүжилтэд нөлөөлдөг.	Хог хаягдлын тухай хуулийн 41.7. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно. 41.11. Хог хаягдлыг булшлах үйл ажиллагааг энэ хуулийн 9.1.4-д заасан тарифыг үндэслэн булшилсан хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ. Хог хаягдлын тухай хууль 41.7. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно. 41.11. Хог хаягдлыг булшлах үйл ажиллагааг энэ хуулийн 9.1.4-д заасан тарифыг үндэслэн булшилсан хог хаягдлын хэмжээгээр тооцож санхүүжүүлнэ.
	Хог хаягдлын хураамжийг иргэнд тооцож авдаг систем бүрдээгүй; Иргэд болон ААНБ үйл ажиллагаанаас үүсгэж байгаа хог хаягдлын норматив, хэмжээ тодорхой	Хог хаягдлын тухай хуулийн 41.6. Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно гэсэн байдаг.



Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
	бус. Хуульд заасан иргэн бүрээр ХХ үйлчилгээний хураамж (аргачлалын дагуу тооцсон) төлөх заалт хэрэгжихгүй, УБ хотын дүүргүүд болон аймгуудын сумын ИТХ хуулийн дагуу хог хаягдлын хураамжийг тогтоогүй байна.	
Нийгмийн асуудлууд	Жолооч, ачигч нарын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлууд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиар жолооч, ачигч нарын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлыг зохицуулсан байдаг.
Технологи, дэд бүтцийн асуудлууд	Хотын төвөөр дахивар цуглуулж, тээвэр хийхэд зөвшөөрлийн асуудал хүндрэлтэй байдаг.	Ачааны автомашиныг хотын төвийн зарим гудамжинд зөвшөөрөлтэй хөдөлгөөнд оролцуулах журам нь 2009 оноос эхлэн мөрдөгдөж эхэлсэн байна. Нийслэлийн гудамж, замын хөдөлгөөнд ачааны автомашиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрөл авах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага холбогдох баримтыг бүрдүүлж “Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ” буюу www.smartcar.mn , төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn сайтыг ашиглан түр зөвшөөрөл хүссэн материалыг илгээж авдаг байна.
ДАХИН БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД		
Захиргаа, менежментийн асуудлууд	Үйл ажиллагаа явуулах газрын болон бусад төрлийн тусгай зөвшөөрөл авахад хүндрэлтэй.	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1-р зүйлд аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх болон энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн, хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэхэд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахаар заасан байна. Хог хаягдлын тухай хуулийн 40.8. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах байгууламж болон хог хаягдлын төвлөрсөн цэг, үйлдвэр технологийн паркийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг Газрын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.
	Ихэвчлэн үйл ажиллагаа явуулах өөрийн эзэмшлийн газар байхгүй, түрээсийн газарт үйлдвэрлэл явуулдаг.	
	Хуванцар бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг эргүүлэн татах, цуглуулах систем бүрэн бүрдээгүй учир түүхий эдийг цуглуулах хүндрэлтэй	Хог хаягдлын тухай хуулийн 40.5. Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй гэж заасан хэдий ч хэрэгжүүлэх арга хэмжээг заасан журам, зохицуулалт байхгүй.
Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн судалгаа, загвар, аргачлал дутагдалтай, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн аль шатанд хуванцар хог	Хог хаягдлын тухай хуулийн 40.6. Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах,	



Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
	хаягдал үүсэж байгааг нарийвчлан тодорхойлж чаддаггүй	булшлах, устгах, экспортлох амьдралын мөчлөгийг харуулсан схемтэй байх ба түүнийг олон нийтэд нээлттэй байлгана.
Санхүү, эдийн засгийн асуудлууд	Үйлдвэрлэл, үйлчилгээнээс үүсэж байгаа хог хаягдлаа багасгасан болон дахин ашиглаж, дахин боловсруулсан, ногоон технологи, хэрэглээ нэвтрүүлсэн ААНБ, иргэдийг урамшуулах, эдийн засгийн хөшүүрэг, дэмжлэг сул, механизм тодорхойгүй	Хог хаягдлын тухай хуулийн 40.4. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгоно.
	Үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлагын тогтолцоо, эрх зүйн орчин бүрдээгүй; Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хаягдалгүй үйлдвэрлэлийн үзэл, баримтлал, ойлголт сул	Хог хаягдлын тухай хуулийн 40.5. Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй гэж заасан хэдий ч хэрэгжүүлэх арга хэмжээг заасан журам, зохицуулалт байхгүй.
	Зээлд хамрагдахад үүсдэг асуудлууд (барьцаа, эргэлтийн хөрөнгө г.м)	МУ-ын ихэнх Арилжааны банкнууд нь Олон улсын банк болох стратегийн зорилгын хүрээнд даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилгыг хэрэгжүүлэх, Ногоон банк болох гэсэн зорилтуудыг тодорхойлж, эдгээрийн биелэлтийг хангахад чиглэсэн “Ногоон сэргэлтийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлдэг бөгөөд уг хөтөлбөрийн хүрээнд харилцагч нарынхаа урт удаан хугацааны тогтвортой үйл ажиллагаа болон ногоон бизнесийг дэмжих зорилго бүхий “Бизнесийн ногоон зээл”-ийн бүтээгдэхүүнийг тааламжтай нөхцөлтэйгөөр (хүү шимтгэл багатай, хугацаа урттайгаар) зах зээлд нэвтрүүлсэн байдаг.
	Санхүүгийн мэдлэг боловсрол дутмаг, санхүүгийн болон зээлийн материал бүрдүүлэлт хангалттай хийж чаддаггүй.	Хатуу хог хаягдлын тогтвортой менежмент буюу Хог хаягдлыг цуглуулах, ангилах, дахин боловсруулах эсвэл дахин ашиглах үйл ажиллагаа нь энэхүү хөтөлбөрт хамрагддаг.
	Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, хог хаягдлын хэмжээг бууруулснаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, мөн шинээр ажлын байр бий болгож байгаа гэх зэрэг эерэг үзүүлэлтийг ногоон зээл олгоход харгалзан үзэх	Дотоодын дахин боловсруулагч нараа дэмжих, зах зээлийг өргөжүүлэх, хогийн уутны хаягдлыг багасгахын тулд гаалийн татварын бодлогыг өөрчлөх шаардлагатай
Монгол улсад хуванцар хаягдлаар дийлэнх БЖДҮ-үүд хогийн савны уут хийдэг боловч борлуулалтын хувьд асуудалтай байдаг. Гэтэл гаалиар ижил төстэй бүтээгдэхүүн ямар нэгэн зохицуулалтгүйгээр (хямд үнээр) орж ирж байгаа нь дотоодын хуванцар дахин боловсруулагч нарын борлуулалтад болон зах зээлд нөлөөлөн дампууруулах эрсдэлтэй байна.		
Нийгмийн асуудлууд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, түүний	



Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
		ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ MNS 5080:2001” стандарт, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага. MNS 4990:2015” стандартуудаар зохицуулагддаг.
	Дахивар авдаг цэгүүд зөвхөн зарим төрлийн ангилж ялгасан дахивар авдаг учир иргэдийн ангилан ялгах идэвх бүүрдаг. Нөгөөтээгүүр дахивар цэгт ирж буй хаягдлын тал хувь нь дахин боловсруулагдахгүй хуванцар ирдэг ба тэдгээрийг хогийн цэг лүү өөрсдийн зардлаар тээвэрлэж устгадаг.	
	Ажиллах хүчний дутагдал их	Ажил хүчний асуудлыг шийдвэрлэхэд боловсрол, хөдөлмөрийн үнэлгээ, тогтвортой ажлын байраар хангах зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.
Технологи, дэд бүтцийн асуудлууд	Хуванцар дахин боловсруулах үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүдийн цахилгааны хэрэглээ өндөр, төлбөр их гардаг.	Дахивар боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн сонголтыг хийхэд анхаарах шаардлагатай бөгөөд эрчим хүч ашигласны төлбөрийг Эрчим хүчний тухай хууль, журмаар зохицуулагдана.
	Хуванцар дахин боловсруулах үйлдвэрүүдийн технологиуд өөр өөр байдаг. Технологийн нарийвчилсан судалгаагүй, стандарт байхгүй	Технологийн нарийвчилсан судалгаагүй, стандарт байхгүй байна.
	Дахивар авдаг цэгүүдийн нэгдсэн стандарт, шаардлага байдаггүй.	Дахивар авдаг цэгүүдийн нэгдсэн стандарт, шаардлагын талаар тусгасан хууль, эрхзүйн баримт бичиг байхгүй байна.
ДАРЖ БУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД		
Захиргаа, менежментийн асуудлууд	Хог хаягдлын төвлөрсөн цэг, түр цэг, гудамж талбай, зам дагуу болон хөдөө орон нутагт хуванцар хог хаягдал ихээр хаягддаг. Тэдгээр хог хаягдлуудын ихэнх хувь нь дотоодын үйлдвэрлэгч нарийн бүтээгдэхүүний хуванцар сав, шил байна.	Хог хаягдлын тухай хуулийн 10.3-р зүйлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно: 10.3.1. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях; 10.3.2. Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях; 10.3.3. Хог хаягдлыг ил задгай шатаах; 10.3.4. Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах; 10.3.5. Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях; 20.1. Хог хаягдлын төвлөрсөн цэгт дараах хог хаягдал булшлахыг хориглоно: 20.1.1. Аюултай хог хаягдал; 20.1.2. Халдвартай хог хаягдал; 20.1.3. Шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал.



Тодорхойлсон асуудал		Хууль эрхзүйн баримт бичигт тусгасан зохицуулалт
		<p>Мөн шат шатны төрийн захиргааны байгууллагуудад хяналт тавих эрх, үүргийг зааж өгсөн.</p> <p>40.5. Энэ хуулийн 8.1.14-т заасан жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүрэгтэй гэж заасан хэдий ч хэрэгжүүлэх арга хэмжээг заасан журам, зохицуулалт байхгүй.</p>

3 ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА, ХУУЛЬ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТУУД

Олон улсад хуванцар хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлд олон төрлийн зохицуулалтыг ашигладаг бөгөөд хамгийн түгээмэл ашиглагддаг санхүүгийн хөшүүрэг, зохицуулалтын жишээнүүдийг дор дурдан орууллаа. Монгол улсын нөхцөлд хуванцар хог хаягдлын менежментийг сайжруулахад хамгийн түрүүнд санхүүгийн хөшүүрэг, зохицуулалтыг ашиглах нь чухал ач холбогдолтой бөгөөд ийм төрлийн санал оролцогч талуудтай хийсэн уулзалт, хэлэлцүүлгийн үеэр ч олон давтагдаж байсан юм.

Санхүүгийн зохицуулалт, хөшүүргийг ашиглан хогийн цэг дээр дарж булах хуванцар хог хаягдлын хэмжээг бууруулахаас гадна дахин боловсруулах хувь хэмжээг нэмэгдүүлэх боломжтой юм. Санхүүгийн хөшүүрэг нь олон улсад 2 төрөл байна. Үүнд:

1. Урамшуулал (дахин боловсруулсны урамшуулал),
2. Төлбөр (хаяж байгаагийнхаа хирээр төлбөр төлөх)

Олон улсад зарим түгээмэл ашиглагддаг санхүүгийн зохицуулалтын төрлүүдийг дараах бүлгүүдэд авч үзэв.

3.1 Нэг удаагийн хэрэглээний хуванцрын татвар (Single use plastic levy)

Нэг удаагийн хэрэглээний гялгар уут, хуванцар сав, баглаа боодлын хэрэглээг бууруулах зорилгоор эдгээр бүтээгдэхүүнд ноогдуулах татварыг нэг удаагийн хуванцрын татвар гэнэ. Энэхүү татварыг нэвтрүүлснээр иргэд, ААНБ-үүд хаягдалгүй эдийн засгийг дэмжсэн үйл ажиллагааг явуулах боломжтой болох юм. Нэг удаагийн хуванцрын татвар нь нэг удаагийн хуванцрыг дахин боловсруулах, устгах өртөг, зардлыг өөртөө шингээсэн байх бөгөөд нэг удаагийн хуванцрыг дахин боловсруулах нь эдийн засгийн хувьд үр өгөөжтэй үйл ажиллагаа болох юм. Нэг удаагийн хуванцрын татварыг нэвтрүүлснээр эдгээр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх бөгөөд ингэснээр ийм төрлийн бараа, бүтээгдэхүүнээс татгалзах, орлуулах сэдэл бий болно.

Нэг удаагийн хуванцрын татварыг нэвтрүүлэхээс гадна орлуулах бараа бүтээгдэхүүнийг дэмжих санхүүгийн хөшүүрэг бий болгох нь үр дүнтэй. Энэ хоёр арга хэмжээг хослуулан авч хэрэгжүүлснээр 1) инновацыг дэмжинэ; 2) иргэд, ААНБ-үүдын дадал, хэвшилд өөрчлөлт орно.

Нэг удаагийн хуванцрын татварыг нэвтрүүлсэн улс орнуудын жишээг авч үзвэл:

- **Ирланд улс, “Latte Levy” буюу нэг удаагийн кофены аяганы хэрэглээг бууруулах зорилгоор нэвтрүүлсэн татвар.** 2022 оны байдлаар Ирланд улс “Latte levy” буюу нэг удаагийн кофены аяганд 0.25 центийн татвар ноогдуулсан байна. Энэхүү арга хэмжээнээс төвлөрүүлсэн орлогыг хог хаягдлыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжихэд зарцуулсан. Урт хугацаандаа хүйтэн ундаа савладаг болон бусад төрлийн нэг удаагийн хуванцар сав, савлагаа дээр байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тооцон үзсэний үндсэн дээр татвар ноогдуулна. Одоогийн байдлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна:
 - Сонгогдсон хотууд, их дээд сургуулиуд, тээврийн хэрэгслүүд, худалдааны төвүүдэд нэг удаагийн кофены хуванцар аяга хэрэглэхийг бүрэн хориглохыг туршилтын журмаар хэрэгжүүлэх
 - Суугаад үйлчлүүлж болдог кафе, хоолны газруудад шаардлагагүй нөхцөлд нэг удаагийн кофены хуванцар аяга хэрэглэхийг бүрэн хориглох, дахин ашиглах боломжтой аяга ашиглаж байгаа үйлчлүүлэгч нарт хөнгөлөлт олгох
 - Олон нийт рүү чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах
- **Нэг удаагийн уутны татвар (Carrier bag tax).** Ирланд улс нь 2002 онд гялгар уутанд 0.15 евроны татвар ноогдуулсан. Гялгар уут худалдан авч буй үйлчлүүлэгчид энэхүү татварыг төлөх бөгөөд хэсэгчлэн эсвэл бүтнээр нь полителен ашиглаж хийсэн уутанд хамааралтай татвар юм.

Засгийн газрын зүгээс татварын хэмжээг тодорхойлохдоо худалдан авагч нарын дунд судалгаа явуулсан бөгөөд судалгаагаар нэг худалдан авагч дунджаар нэг гялгар уутанд 0.024 евро зарцуулах сонирхолтой гэж гарчээ. Гэвч татварыг судалгаагаар гарсан дундаж үнэлгээнээс 6 дахин өндөр буюу 0.15 евро гэж тогтоосон байна. Ингэснээр гялгар уутны хэрэглээг 90 орчим хувиар бууруулж чаджээ.

3.2 Дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих санхүүгийн хөшүүрэг (Recycling incentive schemes)

Дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих санхүүгийн хөшүүргийг нэвтрүүлснээр иргэд, айл өрх, ААНБ-үүдэн дахин ашиглах, дахин боловсруулах сэдлийг нэмэгдүүлж, эх үүсвэр дээр үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулж, мөн дахин боловсруулах үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг босгоход ач холбогдолтой.

Санхүүгийн хөшүүрэг нь 2 төрөл байна. Үүнд:

1. Урамшуулал (дахин боловсруулсны урамшуулал),
2. Төлбөр (хаяж байгаагийнхаа хирээр төлөх төлбөр)

Дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих үүднээс урамшууллыг өгөх бөгөөд урамшуулал нь иргэд, иргэдийн бүлгүүдэд өгөх ваучер хэлбэртэй байж болно.

Ваучер өгөхөөс гадна эх үүсвэр дээр нь хог хаягдлыг идэвхтэй ангилан ялгаж байгаа иргэдийн хогны төлбөр, хураамжийн хэмжээг бууруулах нь сайн хөшүүрэг болдог.

Жишээ нь:

- **Хонконг** нь 2020 оны 11 сарын 16-аас “GREEN\$” буюу “Ногоон койн”-той смарт карт гэдэг хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа. Ингэснээр иргэд дахивар цуглуулах цэгүүдээр илүү идэвхтэй үйлчлүүлдэг болсон. 2кг-аас багагүй дахивар авчирснаар иргэд “GREEN\$” смарт картдаа койн цуглуулах боломжтой болох юм. Дахивар цуглуулах цэгт ирэхдээ “GREEN\$” смарт картыг уншуулна эсвэл картын ард байрлах QR кодыг уншуулснаар ногоон койн цуглуулж, койноороо бэлэг сонгож авах боломжтой болно¹.

3.3 Барьцаа мөнгө байршуулж, дахивар тушаах систем (Deposit refund scheme)

Худалдан авагчид бага хэмжээний барьцаа мөнгө байршуулаад худалдан авсан бүтээгдэхүүнийхээ хуванцар дахиврыг авчирч тушаахдаа барьцаа мөнгөө авдаг систем юм. Худалдан авагчдын буцаан авчирч тушаасан хуванцар дахиврыг дахин боловсруулж, хоёрдогч түүхий эд болгон бэлтгэн боловсруулдаг. Ийм төрлийн үйл ажиллагааг ихэвчлэн төрийн байгууллага эсвэл төрийн байгууллагын захиалгаар ямар нэгэн бие даасан байгууллага зохион байгуулж хэрэгжүүлдэг. Ийм системийг нэвтрүүлж хөгжүүлэхийн тулд эхнээс нь төгсгөл хүртэл бүх үе шатыг нарийн төлөвлөх шаардлагатай. Өөрөөр хэлбэл бүх хэрэгтэй дэд бүтцийг бий болгохоос эхлээд барьцаа төлбөрийн тооцооны хяналт зэргийг сайтар хийх шаардлагатай.

Энэ нь “Бохирдуулагч нь төлөх” гэдэг зарчмыг практикт нэвтрүүлж байгаа нэг хэлбэр бөгөөд санхүүгийн хөшүүргээр дамжуулан иргэдийг хаяхын оронд дахин боловсруулахад сэдэлжүүлдэг.

Ихэвчлэн ус, ундааны хуванцар, металл, шилэн сав, савлагануудыг эргүүлэн цуглуулахад ийм төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд эдгээрийг хоёрдогч түүхий эд болгож хувиргахад илүү амар хялбар байдаг. Савлагааны төрлөөс хамаараад төлөх барьцаа төлбөрийн хэмжээ өөр өөр байх боловч Европт ихэвчлэн 0.10 - 0.50 евро хооронд хэлбэлздэг.

¹ Эх сурвалж: https://www.wastereduction.gov.hk/en/community/crm_intro.htm

Жишээ нь:

- Европт ийм төрлийн үйл ажиллагааг Хорват, Дани, Эстони, Финлянд, Герман, Исланд, Литва, Голланд, Норвег болон Швед гэсэн 10 улс оронд аль хэдийнээ хэрэгжүүлсэн байна. Эдгээр улсууд бүгд тодорхой хэмжээнд үр дүнд хүрсэн бөгөөд хамгийн амжилт багатай хэрэгжсэн улс нь Эстони боловч дахивар буцаан авчирч тушаасан хувь хэмжээ 82.7% байсан байна.
- Дээрх улсуудаас хамгийн амжилттай жишээ нь Норвег улс бөгөөд хуванцар дахивар буцаан авчирч тушаасан хувь нь 97% байна. Германд мөн өндөр амжилттай хэрэгжсэн ба хүн ам хамгийн ихээс гадна энэхүү системийн хүрээнд хуванцар, металл болох хөнгөн цагаан, шил зэргийн дахиврыг цуглуулсан бөгөөд дахин буцаан авчирч тушаасан хувь нь 98.4% байна.
- Норвег улсад энэхүү үйл ажиллагааг 1996 оноос хойш зохион байгуулж хэрэгжүүлсэн бөгөөд 10 орчим жил үйл ажиллагааг хэрхэн, яаж үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжүүлэх вэ гэдэг талаар судалгаа, хэлэлцүүлэг, түршилт өрнүүлсний эцэст хэрэгжүүлсэн. Энэ үйл ажиллагааны хүрээнд ус, ундааны PET савыг эргүүлэн цуглуулдаг (зөвхөн ус, ундааны, энд хоолны юмүү ахуйн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний хуванцар сав, савлагаа хамаардаггүй). Мөн ус, ундааны хөнгөн цагаан болон бага хэмжээний HDPE төрлийн хуванцрыг цуглуулдаг. Худалдан авагчид барьцаа төлбөрөө 3500 гаруй дахивар цуглуулах автомат машинуудын аль нэгнээс нь очоод авч болно. Эдгээр автомат машинаар дамжуулан ус, ундааны савны 93% дахиврыг цуглуулдаг. Үлдсэн 7%-ийг гар аргаар цуглуулдаг бөгөөд 11,500 бүртгэлтэй дахивар цуглуулах цэгүүдээр дамжуулан цуглуулна. Тухайлбал 1 ширхэг 330 мл-ийн хуванцар савны дахиврыг буцаан аваачиж тушааснаар худалдан авагчид 1 крон буюу ойролцоогоор 0.10 евро авна. 1 ширхэг 2 литрийн хуванцар саванд 2.5 крон буюу 0.26 евро авна.

3.4 Хог хаягдал дахин боловсруулах зардал шингээсэн төлбөр (Advanced Disposal Fees)

Хог хаягдал дахин боловсруулах зардал шингээсэн төлбөр гэж тухайн нэг бараа, бүтээгдэхүүний хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах зардлыг тухайн бараа, бүтээгдэхүүний үнэнд шингээж худалдахыг хэлнэ.

Хог хаягдал дахин боловсруулах зардал шингээсэн төлбөрийг аливаа бараа, бүтээгдэхүүнийг худалдах цэгт авдаг буюу бараа, бүтээгдэхүүний үнэнд шингээн тооцдог. Өөрөөр хэлбэл тухайн бараа, бүтээгдэхүүний амьдралын мөчлөг дуусах үед хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах зардлыг шингээдэг гэсэн үг юм. Барьцаа төлбөрийн системээс ялгаатай нь энэ төлбөрийг худалдан авагчид буцаан олгодоггүй.

Энэ төрлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй хэрэгжүүлж чадвал худалдан авагч болон үйлдвэрлэгчийн аль алиных нь дадал, хэвшлийг өөрчлөх боломжтой.

Аливаа нэг бараа, бүтээгдэхүүний бүх төрлийн үнэнд энэхүү зардлыг шингээж чадвал цаашид тухайн бараа, бүтээгдэхүүнээс арай бага хэмжээгээр худалдан авах болно. Аливаа бараа, бүтээгдэхүүний зөвхөн зарим төрлийн үнэнд ийм зардлыг шингээж байвал үнийн дүнгээс хамаарч худалдан авагч сонголт хийх болно.

Ийм төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлснээр хог хаягдал цуглуулах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжиж, сайжруулах боломжтой. Мөн худалдан авагчийн шийдвэр, дадал, зуршилд нөлөөлөхөөс гадна хуванцрыг эх үүсвэр дээр нь бууруулах ч боломжийг олгоно.

Хамгийн түгээмэл ашигладаг жишээ бол хог хаягдал дахин боловсруулах зардлыг шингээсэн гялгар уутны төлбөр бөгөөд одоогоор дэлхийн 37 гаруй улсад хэрэгжиж байна.

3.5 Сав, баглаа боодлын төлбөр (Packaging material fees)

Сав баглаа боодлын төлбөр гэдэг нь үйлдвэрлэгчид өөрсдийн үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүнд хэр их хэмжээний сав, баглаа боодол хийж байгаагаас хамаараад төлдөг төлбөр юм.

Сав, баглаа боодлын төлбөрөөс олсон орлогоор сав, баглаа боодлын хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах чиглэлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Ийм төрлийн үйл ажиллагааг хог хаягдлын менежментэд үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хариуцан зохион байгуулдаг газар хийж болно.

Маш олон хөгжиж буй орнуудад дотоодын нийт орлогын 0.5-аас бага хувийг хог хаягдлын менежментийг хийхэд зарцуулдаг. Сайн туршлага бүхий улс орнуудад хамгийн багадаа Дотоодын нийт орлогын 1% байдаг. Сав, баглаа боодлын төлбөрөөс олсон орлого нь төрийн төсвөөс гадна хог хаягдлын менежментийг дэмжих бас нэгэн орлогын эх үүсвэр болох юм.

Сав, баглаа боодлын төлбөрийг дараах 2 аргаар хэрэгжүүлж болно. Үүнд:

- Үйлдвэрлэгчид, импортлогчид нийлээд тус бүр ямар төрлийн хэдий хэмжээний сав, баглаа боодлын хаягдал үүсгэж байна вэ гэдгээс хамаараад нэгдсэн санд мөнгө төвлөрүүлэх. Сангийн менежментийг үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлагын асуудлыг хариуцсан байгууллага хариуцан хэрэгжүүлэх боломжтой. Гэхдээ зарим тохиолдолд үйлдвэрлэгч, импортлогч нар заавал нэгдэж нийлэхгүйгээр тус бүртээ сав, баглаа боодлын хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх үүрэг хүлээж хэрэгжүүлдэг бөгөөд хэрэгжилтийг тодорхой заасан байгууллагад тайлагнадаг.
- Үйлдвэрлэгч, импортлогч нар тус тусдаа үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлагын асуудлыг хариуцсан байгууллагатай гэрээ байгуулж, асуудлыг шийдвэрлэх. Энэ арга замыг сонгосон тохиолдолд байгууллага тус бүрээр хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тооцож болохоос гадна үйл ажиллагааны үр дүн үйлдвэрлэгчээс өөрөөс нь түлхүү хамаарах юм.

Бүгд Найрамдах Чех улс нь ЕКО-КОМ буюу сав, баглаа боодлын хог хаягдлыг эргүүлэн татах, буцаан цуглуулах нэгдсэн системийг айл өрх болон аж ахуйн нэгжээс гарах сав, баглаа боодлын хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах зорилгоор бий болгож, нэвтрүүлсэн. Аж ахуйн нэгж байгууллагын сав, баглаа боодлын хаягдлыг бизнесүүдээр дамжуулан цуглуулдаг бол айл өрхийн ийм төрлийн хаягдлыг хотын хог хаягдлыг ангилах, цуглуулах тогтолцооны хүрээнд цуглуулж, дахин боловсруулдаг. Системийн найдвартай ажиллагааг хангахын тулд ЕКО-КОМ нь тус улсын 6,000 гаруй орон нутгийн захиргааны нэгжтэй гэрээтэй ажиллаж байна.

Тус системийг БНЧУ-ын хог хаягдал болон сав, баглаа боодлын хуулийн хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд хуульд заасны дагуу:

- Сав, баглаа боодлын үйлдвэрлэгчид болон сав, баглаа боодол бүхий бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, импортлогчид, дистрибьютерүүд нь сав, баглаа боодлын хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах үүрэгтэй. Тэд ЕКО-КОМ системийн хүрээнд хотын хог хаягдлыг ангилан цуглуулах үйл ажиллагааг хамтран санхүүжүүлдэг.
- Хотын захиргаад нь хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үүрэгтэй байдаг. Хотын хог хаягдлын тодорхой хэсэг нь сав, баглаа боодлын хаягдал байдаг бөгөөд үүнийг ч мөн адил дахин боловсруулалтад оруулах үүрэгтэй.

ЕКО-КОМ компани нь хамтран ажиллах талуудад бүгдэд нь ижил нөхцөл бүхий саналыг тавьж хамтран ажилладаг бөгөөд тус компани нь сонин, телевиз, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд

зориулсан хөтөлбөр болон онлайн сувгуудыг ашиглан улс орон даяар олон нийтэд мэдээ, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг давхар зохион байгуулдаг байна².

3.6 Үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлага (Extended Producer's Responsibility, EPR)

Үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцлага (ҮИХ) гэдэг нь үйлдвэрлэгч, импортлогч нар нь өөрсдийн үйлдвэрлэж эсвэл импортоор оруулж ирж буй бараа, бүтээгдэхүүнээс гарах хог хаягдлын тодорхой хувь, хэмжээг цуглуулж, дахин боловсруулах үүрэг хүлээдэг.

ҮИХ -ын хүрээнд тухайн бараа, бүтээгдэхүүний хог хаягдлын менежменттэй холбоотой хариуцлагыг үйлдвэрлэгч, импортлогч нарт хариуцуулж байгаа бөгөөд дараах үндсэн хоёр зорилготой.

- Улс, хотын төсөвт ирэх ачааллыг бууруулах, үйлдвэрлэгч, импортлогч нарт тодорхой хэмжээний санхүүгийн хариуцлага үүрүүлэх
- Үйлдвэрлэгч болон импортлогч нар илүү байгаль орчинд ээлтэй, түүхий эдийг хэмнэлттэй ашигласан бараа, бүтээгдэхүүн санал болгоход хөшүүрэг болох

ҮИХ -ын тогтолцоог бусад улс орнуудад 1970-аад оноос хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч сүүлийн арваад жилд илүү идэвхтэй хэрэгжүүлж байна. Бараа, бүтээгдэхүүнээс үүсэх хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулахтай холбоотой зардлыг үйлдвэрлэгч, импортлогч нар хариуцсанаар төсөвт ирэх ачааллыг бууруулах боломжтой. Тухайлбал Бельги улсад 134 сая евро, Германд 1 тэрбум еврог жилд ийм төрлийн арга хэмжээний хүрээнд цуглуулж чаддаг.

ҮИХ -ын системийг нэвтрүүлснээр хуванцар хог хаягдал, тэр дундаа хуванцар сав, баглаа боодлын хаягдлыг үр дүнтэй цуглуулах систем бий болж чаддаг. Ер нь одоо цагт сав баглаа боодлоос гарч байгаа хог хаягдлын бараг тал хувийг цуглуулах, дахин боловсруулах зардлыг үйлдвэрлэгч, импортлогч нар гаргаж байна. Төрөөс хангалттай санхүүжилт хийж чадахгүй байгаа хөгжиж буй орнуудад ийм системийг үр дүнтэй хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Ийм төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа чухал үүрэгтэй бөгөөд шаардлагатай дэд бүтцийг бий болгож чадвал амжилттай хэрэгжинэ.

ҮИХ -ын системийг албадмал эсвэл сайн дурын үндсэн дээр гэсэн 2 төрлөөр хэрэгжүүлж байна.

Албадмал ҮИХ -ын хүрээнд тодорхой хууль, эрх зүйн баримт бичигт зааж, тусгасны дагуу үйлдвэрлэгчид, импортлогчид шаардлагыг биелүүлж ажиллах бөгөөд хэрвээ шаардлагыг биелүүлээгүй бол хариуцлага хүлээх юм. Сайн дурын ҮИХ -ыг төр, хувийн хэвшил болон бусад оролцогч талууд гэрээний үндсэн дээр хамтран хэрэгжүүлж болно эсвэл хувийн хэвшил дангаараа ч хэрэгжүүлж болно³.

3.7 Хуванцрын кредит систем (Plastic credit systems)

Хуванцрын кредит системийн хүрээнд үйлдвэрлэгч нар дахин боловсруулах шаардлагатай хуванцрын хэмжээгээ үндэслэн хуванцар дахин боловсруулдаг итгэмжлэгдсэн үйлдвэрлэгч нараас хуванцар дахин боловсруулсан сертификат худалдан авахыг хэлнэ.

Их Британид ийм төрлийн системийг сав, баглаа боодлын хог хаягдалтай холбоотой нэвтрүүлсэн.

Хувийн хэвшлийн ААНБ-үүд өөрсдийн бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх явцад үүсгэж буй сав, баглаа боодлын хог хаягдлыг офсет буюу дүйцүүлэх боломжтой. Үйлдвэрлэгч нар сав, баглаа боодлын

² <https://www.ekokom.cz/en/clients/downloads/>

³ https://wwf.panda.org/knowledge_hub/all_publications/?356332/Extended-Producer-Responsibility-Project

хаягдлыг бууруулахад хувь нэмэр оруулах үүднээс жил бүр өөрсдийн үүсгэсэн сав, баглаа боодлын хаягдлын хэмжээнээс хамаараад тодорхой тооны “Сав баглаа боодол сэргээх мэдэгдэл- Packaging Recovery Notes” худалдан авах үүрэг хүлээсэн байдаг.

Packaging Recovery Notes (PRN) буюу сав, баглаа боодлын хог хаягдлыг дахин боловсруулж, сэргээн ашигласан тухай мэдэгдлийг хуванцар дахин боловсруулдаг итгэмжлэгдсэн үйлдвэрлэгч нараас авч болдог.

Жил бүр үйлдвэрлэгч нар үүсгэсэн сав, баглаа боодлын хаягдлын хэмжээг тодорхойлж, түүнийг офсет хийхэд хэдий хэмжээний PRN худалдан авах шаардлагатай талаар тооцоолол хийдэг. Хуванцар, цаас, шил, хөнгөн цагаан, төмөр болон мод гэсэн 6 төрлийн материал дээр үйлдвэрлэгч нар ийм төрлийн шаардлагыг биелүүлдэг ба материалаас шалтгаалаад PRN өөр байж болно.

3.8 Ландфилын татвар (Landfill tax)

Ландфилын татварыг нэвтрүүлснээр ландфилд дарж булж буй хог хаягдлын хэмжээг бууруулах, хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулах, бордоо болгох үйл ажиллагааг дэмжих зорилготой.

Ландфилын татварыг ландфил хийх үнэ дээр нэмэлтээр авдаг бөгөөд ландфилд хог хаягдлыг дарж булах хүсэлтэй байгаа компани, ААНБ-аас авна. Ингэснээр дахин боловсруулалтыг дэмжих, ландфил хийхэд байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг татварт тусгах зорилготой. Европын холбооны 18 орон болон Швейцар, Норвег улс ийм төрлийн татвар нэвтрүүлсэн байна.

Ландфил татварыг нэвтрүүлснээр хогийг дарж булснаар үүсэж буй газрын гүний усны бохирдол, хөрсний бохирдол, органик хог хаягдлаас ялгарах метан хий, эвгүй үнэр зэрэг байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах боломжтой.

Мөн татварыг нэвтрүүлснээр хогийг дахин боловсруулах хувь хэмжээ нэмэгдэнэ. Татварыг ихэвчлэн барилгын, аюултай, био хог хаягдлаас авдаг. Ландфилын татвараас гадна хэд хэдэн улс зарим төрлийн хог хаягдлыг ландфил хийхийг хориглосон зохицуулалтыг гаргасан байдаг.

Эдгээр улс орнуудад ландфилын татварыг татварын албаныхан, байгаль орчны асуудал хариуцсан байгууллагууд эсвэл хотын захиргаа цуглуулдаг. 2009-2010 онд ийм төрлийн татвар нэвтрүүлсэн улс орнуудад нийтдээ 2.1 тэрбум еврог ийм төрлийн татвараас цуглуулсан байна.

Татвараас олсон орлогыг улс орон бүр харилцан адилгүй зарцуулдаг. Ихэвчлэн хог хаягдлын менежментийг дэмжих, бохирдсон талбайг цэвэрлэх, болон бусад байгаль орчны үйл ажиллагаанд зарцуулдаг.

3.9 Хог хаягдал шатаах татвар (Incineration taxes)

Хог хаягдал шатаах татварыг хог хаягдал шатаах үйл ажиллагаа явуулдаг ААНБ-аас авах бөгөөд татварыг нэвтрүүлснээр хог хаягдлыг шатаах үйл ажиллагааг багасгаж, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих зорилготой.

Хог хаягдал шатаах татварыг шатаах үйл ажиллагаа явуулах үндсэн үнэ дээр нэмэлтээр авдаг бөгөөд хог хаягдлыг шатаах хүсэлтэй байгаа компани, ААНБ-аас авна. Ингэснээр дахин боловсруулалтыг дэмжих, хогийг шатаахад байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг багасгаж, татварт тусгах зорилготой.

3.10 Төрийн байгууллагын худалдан авалт (Public procurement)

Төрийн байгууллагууд худалдан авалт хийхдээ нэг удаагийн хуванцар худалдан авахыг хориглох боломжтойгоос гадна дахин ашиглах боломжтой, хуванцар биш орлуулах бараа, бүтээгдэхүүнийг худалдан авахыг дэмжих, худалдан авалтын тодорхой хувь хэмжээ тогтоож болох юм. Ингэснээр илүү байгаль орчинд ээлтэй, тогтвортой байдлыг харгалзан үзсэн худалдан авалтыг хийх боломжтой.

Төрийн худалдан авалт нь нэг удаагийн хуванцраас татгалзах, дахин ашиглах боломжтой орлуулах бараа, бүтээгдэхүүнийг дэмжих нэг боломжит арга зам юм. Өөрөөр хэлбэл татвар төлөгчдийн мөнгийг илүү байгаль орчинд ээлтэй байдлаар зарцуулна гэсэн үг юм.

Төрийн худалдан авалтын стандартыг үргэлж шинэчлэн сайжруулж байх хэрэгтэй бөгөөд нэг удаагийн хуванцар худалдан авалтыг хориглох хүртэл арга хэмжээ авах хэрэгтэй бөгөөд дахин ашиглах орлуулах боломжтой бараа бүтээгдэхүүнийг худалдан авах хувь хэмжээ зааж өгөх хэрэгтэй.

Европын Холбооны Хуванцрын хуулийн дагуу хотын захиргаад төрийн худалдан авалтын бодлогодоо өөрчлөлт оруулах, шинэчлэл хийх, хэрэгжүүлэх үүргийг хүлээж байна.

3.11 Холимог санхүүжилт (Blended financing)

Төр, хувийн хэвшил хамтран, холимог санхүүжилт бий болгож, үр ашиг өндөр байх, инновац шингээсэн, шинэлэг дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлж, хэрэгжүүлэх зорилготой.

Уламжлалт хог хаягдлын менежментэд улс орнууд ихэвчлэн төрийн мөнгийг зарцуулдаг. Гэсэн ч энэ нь хангалтгүй юм. Холимог санхүүжилтээр дамжуулан төр, хувийн хэвшил хамтран ажиллаж, хувийн хэвшлийн санхүүжилтийг хог хаягдлын менежментийг хийхэд ашиглаж болох юм.

Холимог санхүүжилтийн арга хэлбэрүүдийг ашигласнаар санхүүжилт дутагдалтай байгаа чухал салбарууд хөрөнгө оруулалт хийж, тогтвортой хөгжлийг хангах боломжтой юм. Мөн холимог санхүүжилтийг ашигласнаар санхүүжүүлэгч, донор байгууллагуудад найддаг байдлыг багасгаж, урт хугацаандаа бие даан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх боломжтой арга хэлбэр рүү шилжиж болох юм.

3.12 Хотын бонд (Municipal bonds)

Урт хугацааны өрийн хэрэгсэл гэж тооцогддог бондыг төрийн байгууллагууд, компаниуд, хотын захиргаад, арилжааны болон хөгжлийн банкнууд гаргах боломжтой бөгөөд бондын санхүүжилтийг ашиглан байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх боломжтой юм.

Хотын захиргаад бонд гаргаснаар урт хугацааны дэд бүтцийн гэх мэт томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломж бүрддэг.

Хотын бонд бусад бондын адил урт хугацаанд зээлэх боломж олгодог (дунджаар 10-20 жил) бөгөөд богино хугацаанд санхүүжилт шаардлагатай байгаа төслүүдийг санхүүжүүлэхэд чухал хэрэгтэй.

Татвартай холбоотой таатай нөхцөлүүд нь хөрөнгө оруулагчдыг татах нэг шалтгаан болдог⁴.

3.13 Хуванцрын банк (Plastic Bank)

Хуванцрын банк хөтөлбөрийн хүрээнд хуванцар дахиврыг зах зээлийн үнээс дээгүүр үнээр үнэлж авах бөгөөд хуванцар дахиврыг бэлэн мөнгөөр эвсэл бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр сольж авах боломжийг олгоно.

Хуванцрын банк хөтөлбөрийн хүрээнд хуванцар дахиврыг бэлэн мөнгөөр, эсвэл бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр, Блокчейнээр баталгаажсан дижитал токеноор сольж болох юм. Ингэснээр хуванцар дахивар цуглуулах үйл ажиллагааг идэвхжүүлэх боломжтой бөгөөд байгальд ил задгай хуванцар хаягдал хаягдахаас сэргийлэх юм. Мөн ядууралд нэрвэгдсэн иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд ч чухал ач холбогдолтой.

⁴ Эх сурвалж:

https://www.researchgate.net/publication/313367892_Municipal_Bonds_as_a_Source_of_Finance_for_Urban_Infrastructure_Development_in_India

Үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд Хуванцрын банк хөтөлбөрийн хүрээнд хуванцар дахиврыг зах зээлийн үнээс дээгүүр үнээр үнэлэн авдаг бөгөөд ингэснээр цуглуулалтыг сайжруулах юм.

Мөн ийм төрлийн хөтөлбөрийн хүрээнд ядуу, эмзэг бүлгийн иргэдэд зориулсан жижиг дэлгүүрийг интерпренерүүд нээн ажиллуулах боломжтой бөгөөд бартер байдлаар худалдаа хийх юм.

Энэ хөтөлбөрийн хүрээнд цуглуулсан хуванцар дахиврыг дахин боловсруулж, Social Plastic буюу нийгмийн сайн сайхны төлөөх хуванцар нэрийн доор өндөр үнээр худалдах боломжтой.

4 ЗӨВЛӨМЖ

Хуванцрын хог хаягдлын менежментийн эрх зүйн зохицуулалтын давхардал, хийдэл, тулгамдаж буй асуудал, түүний шалтгааныг судлан, бусад улс орны эрх зүйн зохицуулалт, практиктай харьцуулан судалсны үндсэн дээр бодлогын баримт бичигт тусгахад шаардлагатай эрх зүйн дараах зохицуулалтыг санал болгож байна. Үүнд:

- Урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ
- Богино хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1 Урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ

Хуванцрын хог хаягдлын менежментийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах урт хугацаанд хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг дараах 2 хувилбараар санал болгож байна. Үүнд:

- **Хувилбар 1.** Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн дүн шинжилгээг хийж, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
- **Хувилбар 2.** Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлага, эко татварын эрх зүйн зохицуулалтыг бий болгох хуулийн төсөл боловсруулж, батлуулах

4.1.1 Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн дүн шинжилгээг хийж, хуульд өөрчлөлт оруулах

МУ-ын Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-р зүйлд “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” хэмээн заасан байдаг бөгөөд Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 онд батлагдаж, хэрэгжиж эхлээд 5 жил болжээ. Иймд энэхүү хуульд заасны дагуу Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, шаардлагатай бол шинэчлэх ажлын хүрээнд дараах өөрчлөлтүүдийг тусгуулснаар хуванцар хог хаягдлын менежментэд тулгарч буй өнөөгийн асуудлуудыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх боломжтой. Үүнд:

- Хуулийн нэр томъёоны тодорхойлолт хэсэгт дараах нэр томъёонуудын тодорхойлолтыг тусгах. Ингэснээр хуванцар хог хаягдлын талаар нарийн тодорхой заалттай болно.
 - Хуванцар хог хаягдал, түүний ангилал
 - Дахин боловсруулагч
 - Дахивар цуглуулагч
 - Зэрэглэл бууруулан боловсруулах
 - Зэрэглэл бууруулан боловсруулагдах хог хаягдал
 - Дахин боловсруулах боломжтой хуванцар
 - Дахин боловсруулах боломжгүй хуванцар
 - Дахивар хүлээн авах цэг
 - Логистик

- 8.1.14 -р зүйл “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах” гэснийг “Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах журам болон зарим бүтээгдэхүүний жагсаалтыг батлах” гэж өөрчлөх.
- 10.3-р зүйл “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой дараах үйл ажиллагааг хориглоно” гэдэгт нэмэлтээр “Дахин боловсруулах боломжгүй нэг удаагийн хэрэглээний хуванцар бүх төрлийн бүтээгдэхүүн, сав баглаа боодлыг бүр мөсөн хориглох” гэж тусгах. Ингэснээр дахин ашиглагдах боломжгүй хуванцар хог хаягдал үүсэхээс сэргийлж, үүсэх хэмжээг бууруулах ач холбогдолтой.
- Дараах заалтуудыг дахивар хог хаягдал тээвэрлэгчдэд хамаарахгүй гэж тусгах. Ингэснээр ангиан ялгасан хуванцар хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах үйл ажиллагаанд дэмжлэг болно.
 - 14.2. Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сүм, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ.
 - 14.3. Энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхлэхийг хориглоно.
 - 14.4. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг энэ хуулийн 14.2-т заасан гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тогтоож, сүм, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөнө.
- 40-р зүйл. Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах хэсэгт бүтээгдэхүүний сав баглаа боодлын стандартчилах тухай заалт нэмэлтээр тусгаж сав, баглаа боодлын дахин ашиглалт, эргүүлэн татах, дахин савлах гэх мэт үйл ажиллагааг хөнгөвчлөн, хуванцар дахин боловсруулах хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
- Тус хуулийн 40.2, 40.3, 40.6 заалтууд нь түнхгийн шинжтэй, ямар нэгэн хэрэгжүүлэх механизмыг хуульд тусгагдаагүй байна. Иймд эдгээр заалтуудын хэрэгжүүлэх механизм, журмыг боловсруулах талаар хуульд нэмж тусгах.

4.1.2 Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлага, эко татварын эрх зүйн зохицуулалтыг бий болгох хуулийн төсөл боловсруулж, батлуулах

Хуванцар хог хаягдал төдийгүй бусад төрлийн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, үүсэхээс сэргийлж, хуванцарын бохирдлын улмаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг багасгахын тулд үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх нь маш чухал.

Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлага гэдэг нь бодлогын зохицуулалтын нэг хэлбэр бөгөөд аливаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь өөрийн үйлдвэрлэсэн, импортлосон бараа, бүтээгдэхүүнээс гарах хог хаягдлыг хариуцахтай холбоотой харилцааг зохицуулах зорилготой.

Тухайн бараа, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн явцад буюу үйлдвэрлэл, тээвэр, логистик, түгээлт, борлуулалт, хэрэглээ, хог хаягдал болох хүртэлх бүх шатанд бүтээгдэхүүний хог хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулахад анхаарал хандуулж ажиллах шаардлагатай гэсэн үг юм. Өөрөөр хэлбэр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх анхдагч түүхий эд, материалыг сонгохоос эхлээд загвар, дизайныг гаргах, хэрэглэгчийн гар дээр очих гэх мэт бүх үе шатанд гарах хог хаягдлын хэмжээг бууруулна.

Дэлхийн улс орнуудад Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын системийг 1980-д оноос хэрэглэж эхэлсэн байна. Энэ арга хэрэгслийг эхний ээлжид томоохон үйлдвэрлэгч орнуудад нэвтрүүлж эхэлсэн

бөгөөд өнөө үед хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах нэг арга хэрэгсэл болгон дэлхий нийтээр ашиглаж байгаа ба олон улсад 400 гаруй ийм төрлийн зохицуулалт байна.

Ийм төрлийн зохицуулалтыг ямар төрлийн бараа, бүтээгдэхүүн дээр түлхүү ашиглаж байгааг үзвэл:

- 35% болоод түүнээс дээш хувь нь электрон бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой
- 17 орчим хувь нь сав, баглаа боодолтой холбоотой
- 12 орчим хувь нь автомашин, автомашины аккумулятор, дугуй зэрэгтэй холбоотой байдаг байна.

Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлагын хүрээнд бүтээгдэхүүний болон сав баглаа боодлын үйлдвэрлэлээс эхлээд худалдаа, хэрэглээ, дахин боловсруулалт, устгал хүртэлх бүх үе шатанд үйлдвэрлэгч болон импортлогч санхүүгийн хариуцлага хүлээх эсвэл эргүүлэн цуглуулах, дахин боловсруулах механизмыг бүрдүүлж, зардлыг хариуцахаар тодорхойлсон байдаг. Энэхүү системийг хог хаягдлын менежментэд нэвтрүүлснээр хог хаягдлыг дарж, булшлах хэмжээ багасаж, хог хаягдлыг дахин боловсруулах хувь хэмжээ маш түргэн өсөж байгааг олон орны жишээн дээр авч үзэж болох юм. Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлагыг нэвтрүүлэхдээ үйлдвэрлэгч болон импортлогч нар зөвхөн бүтээгдэхүүний хэрэглээний дараах үйл ажиллагаанд хариуцлага хүлээхээс гадна бүтээгдэхүүнээс гарах хаягдлыг эргүүлэн цуглуулах болон дахин боловсруулах, устгах зардлыг багасгахын тулд хаягдал багатай бүтээгдэхүүний загвар, дизайныг төлөвлөхөд анхаарч ажилладаг. Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлагын систем нь улс, орны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй хэрэгждэг бөгөөд үйлдвэрлэгч болон импортлогч нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээс эхлээд хог хаягдал болох хүртэлх амьдралын мөчлөгт тодорхой санхүүгийн хариуцлага хүлээх тогтолцоог дэлхий нийтээр нийтлэг хэрэгжүүлж байна.

МУ-д Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлага, эко татварын тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулахын тулд Улсын Үндсэн хуулийн 26.1-р зүйлд *“Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно”*, 26.2-р зүйлд *“Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна”* хэмээн тус тус заасны дагуу хууль санаачлагч нь хууль тогтоомжид заасан хүрээ, хязгаарт нийцүүлэн, хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлага, эко татварын тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг дээр дурдсан хууль санаачлагч хариуцан зохион байгуулах ба дараах үе шатны дагуу хуулийн төслийг боловсруулж, батлуулна.

- 1) Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;
- 2) Хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, батлах;
- 3) Хуулийн төслийг боловсруулах;
- 4) Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;
- 5) Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;
- 6) Хуулийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;
- 7) Хуулийн төсөлд эрх зүйн дүгнэлт хийх эрх бүхий этгээдээс санал, дүгнэлт авах;
- 8) Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;
- 9) Хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх

Үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлага, эко татварын эрх зүйн зохицуулалтыг бий болгох хуулийн төсөл боловсруулахад дараах гол агуулгуудыг тусгах нь зүйтэй. Үүнд:

- Үйлдвэрлэгч болон импортлогч нь бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтээс эхлээд хог хаягдал болох хүртэлх амьдралын мөчлөгт тодорхой санхүүгийн хариуцлага хүлээх тогтолцоог нарийвчлан тусгах;
- Зарим бараа, бүтээгдэхүүн болон түүхий эдийн импортыг хязгаарлах, хориглох, импортын татварыг нэмэх эсвэл импортын квот зааж өгөх. Жишээлбэл: шилэн лонх, хэт нимгэн гялгар уут, тор, хуучин дугуй, хуучин цахилгаан хэрэгсэл, хуучин хувцас, нэг удаагийн дахин боловсруулах боломжгүй сав, бараа, боодол гэх мэт;
- Бараа, бүтээгдэхүүн, түүний сав, баглаа боодлоос үүссэн хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах эсвэл экспортлох үүргийг бие даан хариуцах. Дангаараа энэхүү үүргийг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд бусад үйлдвэрлэгч, импортлогчтой хамтран хариуцаж хэрэгжүүлэх;
- Зарим бараа, бүтээгдэхүүн, түүний сав, баглаа боодлоос үүссэн хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах эсвэл экспортлох үүргийг хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд хог хаягдлыг боловсруулах болон байгаль орчинд халгүй аргаар устгах шаардлага, стандарт хангасан үйлдвэрт шилжүүлэх, дахин боловсруулалтын зардлыг хариуцах;
- Бараа, бүтээгдэхүүн, түүний сав, баглаа боодлоос үүссэн хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах эсвэл экспортлох үүргийг хэрэгжүүлэх боломжгүй бол эко төлбөр төлөх;
- Зарим бараа бүтээгдэхүүний сав баглаа боодлыг нэг стандарттай болгох;
- Зарим бараа, бүтээгдэхүүний сав баглаа боодлыг гаалийн татварын зохицуулалтаар Монгол улсад оруулахыг хориглох, эсвэл өндөр татвар ноогдуулдаг болгож, дотооддоо сав, баглаа боодлыг дахин боловсруулалт, ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх;
- Бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодлыг үр дүнтэй дахин боловсруулах боломжтой материал хэрэглэх, сонголт байгаа тохиолдолд дахин боловсруулагдахгүй материал хэрэглэхийг хатуу хориглох;
- Үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаанаас үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч, импортлогч бие даан эсвэл хамтран хариуцаж, эргүүлэн цуглуулж, дахин ашиглаж, дахин боловсруулж, экспортлох тохиолдолд дараах төрлийн татварын хөнгөлөлт үзүүлэх талаар харгалзан үзэх;
 - Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа ААНБ-ыг НӨАТ-аас тодорхой хугацаанд чөлөөлөх
 - Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг тодорхой хугацаанд гаалийн татвар, НӨАТ-аас чөлөөлөх
 - ААНБ-ын орлогын албан татвараас тодорхой хугацаанд чөлөөлөх
 - Экспортын албан татвараас тодорхой хугацаанд чөлөөлөх
 - Үйлдвэрлэгч, импортлогчийн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт хөрөнгө оруулсан зардлыг үйлдвэрлэгч, импортлогчийг төлөх татвараас чөлөөлөх, хөнгөлөх
- Хог хаягдлын эко төлбөрийг төвлөрүүлэх, захиран зарцуулах талаар;
 - Хог хаягдлын эко төлбөрийн тусгай сан байгуулж болно (Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах замаар)
 - Эсвэл эко төлбөрийг Улсын төсөвт төвлөрүүлэх (Татварын хуульд өөрчлөлт оруулах замаар) боломжтой.
 - Дээрх 2-ын аль ч хувилбар байсан хуримтлагдсан эко төлбөрийг хог хаягдлын менежментийг сайжруулахад оролцож буй оролцогч талуудад дараах хэлбэрийн туслалцаа, дэмжлэг үзүүлэхэд ашиглаж болно:
 - Тусламж (Grant)
 - Татаас (Subsidy)
 - Хүү багатай хөнгөлөлттэй зээл (Low interest loan)

- Зээлийн батлан даалт гаргах
- o Дараах үйл ажиллагаанд зарцуулж болно.Үүнд:
 - Хог хаягдлыг дахин ашиглах, дахин боловсруулахыг дэмжих үйл ажиллагаа (дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ, дахин боловсруулаагүй тохиолдолд хог хаягдлаас үүсэх байсан хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ зэрэг үзүүлэлтээр үр дүнг хянах боломжтой)
 - Хог хаягдлыг эх үүсвэр дээр бууруулах, ангилан ялгалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа
 - Олон нийт рүү хандсан мэдээ, мэдээллийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа
 - Хог хаягдлын менежментийг сайжруулах байгаль орчинд ээлтэй техник технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлийн судалгаа явуулахад туслах үйл ажиллагаа
 - Хог хаягдлын төвлөрсөн цэгийг нөхөн сэргээх, шинэчлэх үйл ажиллагаа

4.2 Богино хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээ

Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах болон шинээр хуулийн төсөл санаачлахаас гадна хуванцар хог хаягдлын дахин боловсруулах үйл ажиллагаанд тулгамдаж буй зарим асуудлуудыг богино хугацаанд хэрэгжүүлэх болох зарим арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх боломжтой.

Тухайлбал Засгийн газар, аймаг, нийслэлийн хэмжээнд хэрэгжиж байгаа хог хаягдлын менежменттэй холбоотой журам, стандартуудад өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах замаар хуванцрын хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаанд санхүүгийн хөшүүрэг, урамшууллын механизмыг бий болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:

- Хуванцар хог хаягдлын дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих зорилгын хүрээнд **Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1-р зүйлд** Хуванцар дахин боловсруулах үйлдвэрийн тоног, төхөөрөмж гэж тусгуулах, хуванцар хог хаягдал дахин боловсруулж байгаа ААНБ-ыг орлогын албан татвараас тодорхой хугацаанд чөлөөлөх эсвэл хэмжээг багасгах байдлаар дэмжлэг үзүүлэх нь үр дүнтэй.
- **Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйл.** Гаалийн татвараас чөлөөлөгдөх бараа хэсэгт “Хог хаягдал (хуванцар) дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрийн тоног, төхөөрөмж” гэж тусгуулах. Хог хаягдал боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргах, коджуулах асуудлыг шийдвэрлэж “Жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх” жагсаалтад оруулах,
- **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.6-р зүйлд** байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийг борлуулсан орлогод ногдох албан татварын хөнгөлөлт үзүүлнэ гэж заасны дагуу Засгийн газрын 2019 оны 468 дугаар тогтоолоор баталсан “Байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд ээлтэй техник, тоног төхөөрөмжийн жагсаалт⁵”-д Хог хаягдал (хуванцар) дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрийн тоног, төхөөрөмж гэж тусгуулах
- **Хог хаягдлын тухай хуулийн 40.4-т** “Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид эдийн засгийн урамшуулал олгох журам”-ыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, санал өгөх, нийслэлийн төр захиргааны байгууллагатай хамтран ажиллах,

⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210514&showType=1>

журамд хуванцрын хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хэрхэн урамшуулал олгох талаар тусгайлсан бүлэг оруулах

- **Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хүүлийн** 1 болон 2-р зүйлд заасны дагуу батлагдсан Засгийн газрын 2018 оны 234 дүгээр тогтоолын хавсралт “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацын бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт”⁶-д 8477.30.00 код бүхий “Хуванцар савны тусгай бэлдцийг үлээж хуванцар сав болгох үйлдлийг гүйцэтгэх төхөөрөмж” нь газар тариалан, бордооны үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалтад байгаа ба уг жагсаалтыг шинэчилж хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийг тусад нь оруулж зарим инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг нэмж оруулах

Мөн бусад богино хугацаанд авч хэрэгжүүлэх боломжтой дараах арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Хуванцар хог хаягдлын цогц менежментийг сайжруулах төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах;
- Түүхий эд цуглуулах системийг сайжруулах;
- Эх үүсвэр дээр ангилан ялгасан дахивар хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх тогтолцоо, дэд бүтцийг бий болгох;
- Дахивар хаягдлын түүхий эдийн бирж байгуулах замаар үүсгэгч, үйлдвэрлэгчийг шууд холбох;
- Хуванцар сав, хуванцар хаягдлыг хэрэглэгчээс шууд цуглуулах автомат төхөөрөмжийг томоохон зах, худалдааны төвүүд, их дэлгүүр, супер маркетуудад байрлуулах;
- Хуванцар сав, лонхыг эргүүлэн авдаг цэгүүдийг сүлжээ дэлгүүрүүдэд байгуулах;
- Хуванцар сав, шилэн лонхонд мөнгөн барьцаа байршуулах замаар буцаан авалтын хэмжээг нэмэгдүүлэх. Жишээ нь дэлгүүрээс хуванцар сав болон шилэн лонхтой бараа, бүтээгдэхүүн авахдаа мөнгөн барьцааг барааны үнийн дүнд нэмж төлнө. Барьцаа байршуулсан тухай мэдээллийг бараа худалдан авсан төлбөрийн баримт дээр тусгайлан хэвлэх бөгөөд хэрэглэгч худалдан авсан бүтээгдэхүүний сав, лонхыг буцаан тушааж төлбөрийн баримтыг үндэслэн барьцаа төлбөрийг буцаан олгох;
- Агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн байгальд ээлтэй хүүний хөнгөлөлттэй төслийн зээлийн бүтээгдэхүүнд хог хаягдал (хуванцар) дахин боловсруулах, сэргээн ашиглах тоног төхөөрөмжүүдийг оруулах зэрэг болно.

⁶ <https://legalinfo.mn/mn/detail/13608/2/208635>

АШИГЛАСАН МАТЕРИАЛУУДЫН ЖАГСААЛТ

- 1) Хуванцар хаягдлын зохицуулалтыг сайжруулах өнөөгийн эрхзүйн орчны судалгаа, Байгаль орчин, аюулгүй байдлын төв ТББ, 2022
- 2) ЭКОСУМ ТББ-аас Монгол улс дахь хог хаягдлын хямралыг шийдвэрлэхэд зориулан гаргасан зөвлөмжүүд, 2022
- 3) Нэгдсэн Үндэсний Байгууллагын Байгаль орчны хөтөлбөрөөс 2016 онд боловсруулсан Хог хаягдлын нэгдсэн менежментийн хууль эрхзүйн хүрээний гарын авлага
- 4) Бразил улсын Үндэсний хатуу хог хаягдлын бодлого (2010)
- 5) Герман улсын Хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай хууль (2002)
- 6) Япон улсын Материалыг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай үндсэн хууль (2000)
- 7) Нидерланд улсын Байгаль орчны менежментийн тухай хууль (2004)
- 8) Шинэ Зеланд улсын Байгалийн нөөцийн менежментийн тухай хууль (1991), Хог хаягдал бүүрүүлэх тухай хууль (2008)
- 9) Англи улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1990)
- 10) АНУ-ын Бохирдлоос сэргийлэх тухай хууль (1990)
- 11) БНХАУ-ын Хог хаягдлын бохирдлоос сэргийлэх, хяналт тавих хууль (2004)
- 12) Канад улсын Үйлдвэрлэгчийн өргөтгөсөн хариуцлага хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2009)
- 13) Тунис улсын Үндэсний хог хаягдлын хөтөлбөр (1993)
- 14) ӨАБНУ-ын хог хаягдлын хөтөлбөр (2004)
- 15) <https://legalinfo.mn/mn>
- 16) [https://www.researchgate.net/publication/313367892 Municipal Bonds as a Source of Finance for Urban Infrastructure Development in India](https://www.researchgate.net/publication/313367892_Municipal_Bonds_as_a_Source_of_Finance_for_Urban_Infrastructure_Development_in_India)
- 17) https://wwf.panda.org/knowledge_hub/all_publications/?356332/Extended-Producer-Responsibility-Project
- 18) https://www.wastereduction.gov.hk/en/community/crn_intro.htm
- 19) <https://www.ekokom.cz/en/clients/downloads/>